

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Өмнөд Америкийн ямар улсаас Номхон далай руу шууд гарч болох вэ? (1 оноо)
A. Болив B. Парагвай C. Эквадор D. Уругвай E. Суринам
2. Аль нь Атлантын далайн хүйтэн урсгал вэ? (1 оноо)
A. Гольфстрим B. Мозамбик C. Бенгель D. Перу E. Сомали
3. Өдөр солигдох шугам ямар эх газар, далайг дайран өнгөрөх вэ? (1 оноо)
A. Хойд мөсөн далай, Еврази, Энэтхэгийн далай, Антарктид
B. Хойд мөсөн далай, Еврази, Австрали, Энэтхэгийн далай
C. Хойд мөсөн далай, Еврази, Өмнөд Америк, Номхон далай
D. Хойд мөсөн далай, Еврази, Номхон далай, Антарктид
E. Хойд мөсөн далай, Еврази, Номхон далай, Өмнөд Америк
4. Туул гол Сэлэнгэ мөрний хэд дэх эрэмбийн цутгал вэ? (1 оноо)
A. 1 B. 2 C. 3 D. 4 E. Цутгал биш
5. Аль нь Карбоны галавт үүссэн нүүрсний орд газар вэ? (1 оноо)
A. Могойн гол B. Налайх C. Багануур
D. Тавантолгой E. Хар Тарвагатай
6. З.У-ын 90°-ын голдоч манай улсын нутгаар дайран өнгөрдөг нь дэлхийн зүүн хагасын төв дунд оршдог гэдгийг илтгэдэг бөгөөд ямар хотоор дайрч өнгөрдөг вэ? (1 оноо)
A. Баянхонгор B. Алтай C. Өлгий D. Өндөрхаан E. Улаангом
7. Иргэн А сувилалд эмчлүүлэхээр Шаргалжуутын рашаан сувиллын газарт очжээ. Тус рашаан аль аймагт оршдог вэ? (1 оноо)
A. Говь-Алтай B. Ховд C. Өвөрхангай D. Баянхонгор E. Хэнтий
8. Цэгийн оронд тохирох үгийг сонгоорой. Олон төрлийн үйлдвэрлэл нэг дор төвлөрөн оршихыг..... гэж нэрлэнэ. (1 оноо)
A. Үйлдвэрийн бөөгнөрөл B. Үйлдвэрийн хоршилт
C. Үйлдвэрийн төрөлжилт D. Комбинат E. Үйлдвэрийн цэг
9. Үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсвэл жилд Монгол улсын ДНБ-ий 5-аас дээш хувийг үйлдвэрлэж байгаа болон үйлдвэрлэх боломжтой ордуудыг юу гэж нэрлэх вэ? (1 оноо)
A. Стратегийн B. Ердийн C. Түгээмэл
D. Орон нутгийн E. Холимог
10. Махны чиглэлийн үхрийн үүлдэр аль нь вэ? (1 оноо)
A. Уулын Алтай B. Сэлэнгэ C. Хэцийн хүрэн D. Хангай E. Орхон
11. Манай оронд ачаа эргэлтээр тэргүүлдэг тээврийн салбар аль нь вэ? (1 оноо)
A. Авто тээвэр B. Агаарын тээвэр C. Ердийн хөсөг
D. Төмөр замын тээвэр E. Усан тээвэр
12. 1 кг уран нь 3000 тн нүүрс шатаасантай тэнцэх хэмжээний дулаан ялгаруулдаг бол 600 сая тонн нөөц бүхий Багануурын уурхайн нүүрсийг ураны дулаантай харьцуулна уу. (1 оноо)
A. 200000 тн B. 2000 кг C. 200000 кг D. 200 кг E. 20 тн
13. ХӨ 41°30', БУ 74°-ын газарзүйн солбицолд орших хот аль нь вэ? (1 оноо)
A. Москва B. Нью-Йорк C. Лондон D. Бээжин E. Улаанбаатар

14. Сүүлийн жилүүдэд дэлхийн улсуудыг хөгжлийн түвшнээр “Өмнөдийн” ба “Хойдын” гэж ангилах нь түгээмэл болжээ. Дараах улсаас аль нь Хойдын бүлэгт багтах вэ? (1 оноо)
A. Аргентин B. Малайз C. Вьетнам D. Энэтхэг E. Франц
15. НҮБ-ын албан ёсны хэлэнд багтдаг хэлийг сонгоно уу. (1 оноо)
A. Япон B. Хятад C. Итали D. Португали E. Ирланд
16. Ямар нэг улс, бүс нутаг тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээгээр дагнан төрөлжиж түүгээрээ олон улсын зах зээлд татагдан орох үйл явцыг юу гэх вэ? (1 оноо)
A. Эдийн засгийн интеграци
B. Олон улсын хөдөлмөрийн газарзүйн хуваарь
C. Эдийн засгийн чөлөөт бүс
D. Олон улсын тээвэр зуучлал E. Үндэстэн дамнасан корпораци
17. Исламын шашны гол 2 урсгал аль нь вэ? (1 оноо)
A. Сүннизм, Шийзм B. Сүннизм, Хиндүизм C. Шийзм, Жайнизм
D. Сүннизм, Жайнизм E. Сикхизм, Жайнизм
18. Өгөгдсөн бүс нутгаас хүн амын нягтшилаар хамгийн өндөр бүс нутаг аль нь вэ? (1 оноо)
A. Канадын ольтриг B. Сибир C. Сахарын төв хэсэг
D. Баруун Европ E. Төв Азийн их цөл
19. Байгалийн хийн олборлолтоор дэлхийд тэргүүлэгч орнуудыг сонгоно уу. (1 оноо)
A. Энэтхэг, Хятад B. ОХУ, АНУ C. Нидерланд, Мьянмар
D. Норвеги, Судан E. Гүрж, Итали
20. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. XX зууны 40-өөд оноос эхлэн мэдээллийн технологи болон цөмийн эрчим хүч, сансрын техникийн хөгжил шинэ шатанд гарч нийгмийн харилцаа, үйлдвэрлэл, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнд чанарын хувьсгал хийсэн. Энэ үйл явцыггэнэ. (1 оноо)
A. Аж үйлдвэрийн хувьсгал B. Шинжлэх Ухаан Техникийн Хувьсгал
C. Нанотехнологийн хувьсгал D. Нийгмийн хувьсгал
E. Соёл иргэншлийн хувьсгал
21. Энэтхэгийн ба Номхон далайг холбох тээврийн ашигтай байрлалд байрлаж, түүнийгээ хөгжлийнхөө тулгуур хүчин зүйл болгосон боомт буюу хот улс аль нь вэ? (1 оноо)
A. Шанхай B. Кейптаун C. Сингапур D. Каракас E. Сан-Франциско
22. Хүний буруутай үйл ажиллагааны улмаас халуун орны чийглэг ойн талбай багасаж, байгаль орчны асуудал хүчтэй тавигдах болсон бүс нутгийг тодорхойлно уу. (1 оноо)
A. Марокко, Сенегал, Хойд Африк B. Аргентин, Гүрж, Өмнөд Ази
C. Баруун Ази ба Өмнөд Африк D. Сибир, Канад
E. Амазон болон Конгын сав, Гвинейн булангийн орнууд
23. Хятадын Сычуань мужид 2008 байгалийн ямар гамшигт үзэгдэл болсон бэ? (1 оноо)
A. Ойн түймэр B. Газар хөдлөлт C. Галт уулын дэлбэрэлт
D. Үер E. Хар салхи
24. Галт уулын гарал үүсэлтэй рельеф (хотгор гүдгэр)-ийн төрөл аль нь вэ? (1 оноо)
A. Хөөө, шүрэн арал B. Уурхай карьер, ухсан нүх
C. Довцог, элсэн манхан D. Өрх тогоо E. Мөсөн гол, намаг
25. Нарны аймаг дотор нарнаас орших дарааллаар 2-т байх гараг аль нь вэ? (1 оноо)
A. Буд B. Дэлхий C. Сугар D. Сар E. Бархасбадь
26. Дараах орнуудаас хүн ам нь олон үндэстэн угсаатнаас бүрдэх улс аль нь вэ? (1 оноо)
A. Япон B. Швед C. Норвеги D. Энэтхэг E. Өмнөд Солонгос

27. Усны уур бараг байхгүй тул үүлгүй шахам, нийт агаарын 20 орчим хувь нь агуулагддаг агаар мандлын үе давхаргыг нэрлэнэ үү. (1 оноо)

- A. Тропосфер B. Стратосфер C. Мезосфер D. Термосфер E. Экзосфер

28. Цэгийн оронд тохирох үгийг сонгоорой. Газрын гадаргад ил гарч ирсэн магмыг гэнэ. (1 оноо)

- A. Лаав B. Карст C. Кратер D. Хий E. Ус


29. Газрын зураг дээр ижил дулааны утгыг холбосон шугамыг юу гэж нэрлэх вэ? (1 оноо)

- A. Изотерм B. Изогон C. Изогипс D. Изобат E. Изобар

30. Эдийн засгийн Зүүн бүсийн тулгуур хотууд аль нь вэ? (1 оноо)

- A. Бор-Өндөр, Өндөрхаан B. Чойбалсан, Баруун-Урт
C. Баруун-Урт, Бор-Өндөр D. Чойбалсан, Өндөрхаан E. Өндөрхаан, Баруун-Урт

31. Дараах цэгийн солбицлыг тодорхойлно уу. (1 оноо)




- A. $\Theta\Theta 54^{\circ}30'$, $\text{ЗУ } 93^{\circ}30'$
B. $\text{ХӨ } 53^{\circ}30'$, $\text{ЗУ } 95^{\circ}30'$
C. $\Theta\Theta 55^{\circ}30'$, $\text{БУ } 94^{\circ}30'$
D. $\text{ХӨ } 55^{\circ}30'$, $\text{ЗУ } 94^{\circ}30'$
E. $\text{ХӨ } 54^{\circ}30'$, $\text{БУ } 93^{\circ}30'$

32. Дараах гол мөрдийг харьяалагдах ай савтай нь тохируулна уу. (1 оноо)

- | | |
|---------------|--------------------------------------|
| 1. Хэрлэн | A. Хойд мөсөн далайн ай сав |
| 2. Онги | B. Номхон далайн ай сав |
| 3. Дэлгэр | C. Төв Азийн гадагш урсгалгүй ай сав |
| A. 1C, 2B, 3A | B. 1A, 2C, 3B |
| D. 1B, 2C, 3A | E. 1A, 2B, 3C |

33. Зурагт 1-ийн тоогоор тодруулсан Тусгай Хамгаалалттай газар нутгийн нэрийг зөв сонгоно уу? (2 оноо)



- A. Цамбагаравын Байгалийн Цогцолборт газар
B. Бурханбуудай уулын Байгалийн Нөөц газар
C. Увс нуурын Дархан Цаазат газар
D. Онон Балжийн савын Байгалийн Цогцолборт газар
E. Горхи Тэрэлжийн Байгалийн Цогцолборт газар


34. Дараах өгөгдлийг уншаад зөв 2 өгүүлбэрийг сонгоно уу. (2 оноо)

- 1) Чихрийн нишингийг тропикийн чийглэг уур амьсгалтай орнуудад тариалдаг.
- 2) Чихрийн нишингийг зөвхөн экваторын бүсэд л тариална.
- 3) Герман, Франц, Польш нь чихрийн нишингийн гол үйлдвэрлэгч орнууд юм.
- 4) Бразил, Энэтхэг, Куба нь чихрийн нишингийн гол үйлдвэрлэгч орнууд юм.

- A. 1 ба 2 B. 2 ба 3 C. 3 ба 4 D. 1 ба 4 E. 2 ба 4

35. Зураг дээр 9-ийн тоогоор тэмдэглэсэн хилийн боомт аль нь вэ?

(2 оноо)




- A. Боршоо
- B. Цагааннуур
- C. Даян
- D. Ярантай
- E. Бага Илэнх

36. Дэлхийн дулааны бүслүүр дэх халуун бүслүүрийн шинжийг тодорхойлно уу. (2 оноо)

- A. Жилийн $+20^{\circ}\text{C}$ -ийн изотермээр зааглагдана. Хуурай газарт дал модны, далайд шүрийн тархсан хязгаартай давхцана.
- B. Туйл талаасаа хамгийн дулаан сарын $+10^{\circ}\text{C}$ -ийн изотермээр тодорхойлогдоно. Модлог ургамлын тархалтын хил болно.
- C. Туйл талаасаа хамгийн дулаан сарын 0°C -ийн изотермээр зааглах бөгөөд тундрын хилтэй давхцана.
- D. Хамгийн дулаан сарын 0°C -ийн изотерм болон хойд өмнөд туйлын хооронд үүссэн байна.
- E. Экватороос туйл хүртэлх бүх бүслүүрийг хамарна.

37. Зурагт А үсгээр тэмдэглэсэн уулсын тогтолцоог нэрлэнэ үү?


(2 оноо)



- A. Хянганы уулс
- B. Говь Гурван Сайханы нуруу
- C. Бүрэнгийн нуруу
- D. Булнайн нуруу
- E. Хорьдил Сарьдагийн нуруу


38. Асуултын тэмдгийн оронд тухайн газарзүйн объектийн нэрийг сонгоно уу.

(2 оноо)




- A. Арабын тэнгис
- B. Агнуурын тэнгис
- C. Тасманы тэнгис
- D. Карибын тэнгис
- E. Улаан тэнгис

39. Монгол улсын ястнуудын голлон амьдрах нутгийг өнгөт дэвсгэрийн аргаар дүрсэлсэн зурагт 1 ба 2-ын тоогоор ямар ястныг тэмдэглэсэн бэ? (2 оноо)







- | | |
|-------------------------|----------------------------|
| A. 1- Буриад, 2- Мянгад | B. 1- Барга, 2- Торгууд |
| C. 1- Дархад, 2- Захчин | D. 1- Үзэмчин, 2- Урианхай |
| E. 1- Баяд, 2- Захчин | |

40. Зургийг ажиглаад 1-ийн тоогоор заасан хавтангуудын хилийг тодорхойлно уу. (2 оноо)



- A. Ойртон нийлж буй хавтангийн хил зааг
- B. Холдон салж буй хавтангийн хил зааг
- C. Шилжин зөрж буй хавтангийн хил зааг
- D. Хавтангийн хөдөлгөөнийг судлах боломжгүй
- E. Хавтангууд хөдөлдөггүй





41. Дараах фото зургуудыг эх газартай нь зөв тохируулсныг сонгоно уу. (2 оноо)





1.  2.  3.  4. 

A. Австрали B. Африк C. Антарктид D. Хойд Америк

A. 1C, 2A, 3D, 4B B. 1B, 2C, 3A, 4D
D. 1A, 2B, 3C, 4D E. 1B, 2A, 3C, 4D

42. Байрзүйн зургийн таних тэмдгүүдийг зөв харгалзуулсан хувилбарыг нэрлэнэ үү. (2 оноо)


1.  2.  3.  4. 

A.  B.  C.  D. 

A. 1C, 2A, 3B, 4D B. 1C, 2A, 3D, 4B
D. 1A, 2C, 3B, 4D E. 1C, 2D, 3A, 4B

C. 1A, 2C, 3D, 4B

43. Нарны эгц тусгалыг үзүүлсэн тахир шугам дээр A гэж тэмдэглэгдсэн газарт хэдэн сарын хэдний өдөр болж байх боломжтой вэ? (2 оноо)



- A. 9 сарын 23 B. 3 сарын 21 C. 6 сарын 22
D. 12 сарын 22 E. 10 сарын 22

44. Японоос Чили хүртэл өгөгдсөн сумны дагуу (A-аас B) ертөнцийн зүг чигийг тодорхойлно уу. (2 оноо)




- A. Зүүн хойд
B. Баруун өмнөд
C. Баруун хойд
D. Зүүн өмнөд
E. Баруун

45. Голын хөндлөн огтлолын талбай 16 м^2 , урсгалын хурд 1.4 м/с бол голын усны өнгөрөлтийг олоорой. ($Q=S \times V$) (2 оноо)


- A. $21.4\text{ м}^3/\text{с}$ B. $22.4\text{ м}^3/\text{с}$ C. $224\text{ м}^3/\text{с}$ D. $2.24\text{ м}^3/\text{с}$ E. $21.04\text{ м}^3/\text{с}$

46. Зураг дээр 1-ийн тоогоор тэмдэглэсэн улсад эрчимтэй хөгжсөн аж ахуй, үйлдвэрлэл аль нь вэ? (2 оноо)




- A. Машин тоног төхөөрөмж, электроникс, шинжлэх ухааны багтаамжит үйлдвэрлэл
B. Химийн үйлдвэр, хонины аж ахуй, сансрын техникийн үйлдвэрлэл
C. Дарс, улаан буудай, хөлөг онгоцны үйлдвэрлэл
D. Тутарга, уул уурхай, кофены үйлдвэрлэл
E. Оёдол нэхмэл, чихрийн нишингэ, нүүдлийн мал аж ахуй

47. Масштабыг томоос нь жижиг рүү дараалуулан бичсэн хариултыг сонгоно уу. (2 оноо)




- A. 1, 2, 3
- B. 1, 3, 2
- C. 3, 2, 1
- D. 2, 1, 3
- E. 2, 3, 1

48. Зургийг ажиглаад эдийн засгийн Зүүн бүсэд багтах аймгийг олно уу. (2 оноо)




- A. 1 ба 2
- B. 2 ба 4
- C. 1 ба 3
- D. 1 ба 4
- E. 5 ба 6

49. Манай орны уулсад тайгын бүслүүр хэдэн метрийн өндөрт үүсдэг вэ? (2 оноо)




- A. 1800 м хүртэл өндөрт
- B. 1800-2300 м
- C. 2300-3300 м
- D. 3300 м-ээс дээш
- E. Тайгын бүс байхгүй

50. Энэ нөхцөлд хамгийн бага агаарын даралттай цэг аль нь байж болох вэ? (2 оноо)




- A. A цэг
- B. B цэг
- C. C цэг
- D. D цэг
- E. Далайн түвшинд

51. Цэгийн оронд тохирох нэрийг сонгоно уу. Хотгор гүдгэрийн зүсэлт нь эх газрыг Ө.Ө-ийн 30⁰-ын дагуу баруунаас зүүн тийш огтлон гарсан байна. (2 оноо)



- A. Еврази
- B. Австрали
- C. Антарктид
- D. Өмнөд Америк
- E. Европ

52. Сумаар ямар бүтээгдэхүүний экспортын чиглэлийг илэрхийж байна вэ? (3 оноо)



A. Төмрийн хүдэр
D. Цагаан будаа

B. Автомашин
E. Хүнс

C. Гар утас

53. А улсын аялал жуулчлалын салбараас олох орлого 2010 онд 250 сая америк доллар байсан бол 2011 онд 310 сая америк доллар болж өсчээ. Тус салбарын орлогын жилийн өсөлт хэдэн хувь болсон бэ? (3 оноо)

A. 19.3%

B. 28.5%

C. 24%

D. 20%

E. 31%

54. Дэлхийн далайн гүн хонхоруудыг зөв харгалзуулсан хувилбарыг сонгоно уу. (3 оноо)

1. Зондын хонхор

2. Пуэрто Рикогийн хонхор

3. Марианы хонхор

4. Арктикийн хонхор

A. 8605 м

B. 7725 м

C. 5450м

D. 11022м

a. Энэтхэгийн далай

b. Хойд мөсөн далай

c. Атлантын далай

d. Номхон далай

A. 1Ba, 2Ac, 3Db, 4Cd

B. 1Ad, 2Bc, 3Cb, 4Da

C. 1Ba, 2Ab, 3Dd, 4Cc

D. 1Ad, 2Ba, 3Dc, 4Cb

E. 1Ba, 2Ac, 3Dd, 4Cb

55. Манай орны зарим хотуудын жилд унах хур тунадас, агаарын температур болон гадарга, газарзүйн байрлалыг тодорхойлсон хүснэгтийг ажиглаад асуултын тэмдгийн оронд тохирох хотыг сонгоно уу? (3 оноо)

Хотууд	Өргөрөг	өндөр (м) д.т.д	Дундаж температур (t °C)			Жилд унах тунадас (мм)
			жилийн	I сар	VII сар	
?	XӨ 49°58'	939	-3.7°	-32°	+16°	138
Баруун-Урт	XӨ 46°41'	981	+0.6°	-21°	+20°	203.7
Алтай	XӨ 46°22'	2181	-1.5°	-19°	+14°	171.2
Даланзадгад	XӨ 43°34'	1465	+4°	-16°	+21°	129.5

A. Улаанбаатар


B. Мандалговь

C. Арвайхээр

D. Замын үүд

E. Улаангом

56. Монгол улсын хүн амын тооллоготой холбоотой тоон мэдээллүүдийг өгөв. Графикт дүрсэлсэн өгөгдлүүдийг ажиглаад, хариултуудаас үнэн нэг өгүүлбэрийг сонгоно уу? \1000 хүнд ноогдох төрөлт, нас баралт, ердийн өсөлт\ (3 оноо)



- 1969 онд нас баралтын түвшин хамгийн өндөр байна.
- 1979 оноос өнөөг хүртэл төрөлт, нас баралт, ердийн өсөлт бүгд буурч ирсэн.
- 1989 оны төрөлтийн тоо хэмжээ 2010 оны тооллоготой харьцуулахад ижил түвшинд байна.
- Төрөлт ба нас баралтын тоо хэмжээ 1963 оноос хойш өнөөг хүртэл тогтмол буурч ирсэн.
- Төрөлт 1963 онд хамгийн өндөр, нас баралт 2010 онд хамгийн бага байсан байна.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Анхааруулга

- Хоёрдугаар хэсгийн бодлогын хариуг хариултын хуудасны 2-р хэсэгт доорх хэлбэрээр бөглөхийг анхаарна уу. Жишээлбэл, Эцсийн хариу 5650 гэж гарсан бол a-5, b-6, c-5, d-0 гэж бөглөнө.

- АНУ-ын Сиэтл хотын дунд сургуульд Монгол орны нутгийн өмнөд хэсгийн жилийн дундаж температур нь 41°F байдаг тухай заажээ. Энэ нь цельсийн хэдэн градустай тэнцэх вэ? $t^{\circ}\text{C} = 5/9 \times (t^{\circ}\text{F} - 32)$ / (3 оноо)
- А ба В хотын хооронд 5 тн-ын даацтай машинаар цемент ачиж 20 удаа тээвэрлэхдээ 75.000 тн*км ачаа эргэлт хийсэн бол хоёр хотын хооронд хэдэн км зайтай вэ? $(S = E/A)$ (4 оноо)
- Тухайн үеийн агаарын температур $+10^{\circ}\text{C}$, чийгийн багтаамж 10 г/м^3 , харьцангуй чийг 80% байсан бол дутмаг чийгийг олоорой. (4 оноо)
- Чита (8-р цагийн бүс) хотоос Мурманск (2-р цагийн бүс) хот руу 22 цагт хөөрсөн онгоц Мурманскт тухайн бүсийн цагаар 21 цагт буужээ. Онгоц хэдэн цаг ниссэн бэ? (4 оноо)